



АЛБАН ЖУРМЫН  
ДААТГАГЧДЫН ХОЛБОО  
Association of Mandatory Insurers

ᠠᠯᠪᠠᠨ ᠵᠤᠷᠮᠤᠨ  
ᠳᠠᠠᠲᠭᠠᠭᠴᠢᠳᠤᠨ ᠬᠣᠯᠪᠣᠣ  
Association of Mandatory Insurers

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# 2025



1800-1177



[www.ami.mn](http://www.ami.mn)





## **НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1 Товч танилцуулга

1.2 Холбооны 2025 оны үйл ажиллагааны зорилт

## **ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2.1 Даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.2 Жолоочийн даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөр олгох, буцаан нэхэмжлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.3 Зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа

2.4 Хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

2.5 Жолоочоос шалтгаалан гарсан зам, тээврийн ослын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай үнэн, зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэх дуудлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

## **ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

3.1 Санхүүгийн тайлан үр дүнгийн талаар

3.2 Дотоод үйл ажиллагааны талаар



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. **АЖДХ-** Албан журмын даатгагчдын холбоо
2. **СЗХ-** Санхүүгийн зохицуулах хороо
3. **ХХК-** Хязгаарлагдмал хариуцлагатай компани
4. **ШШГЕГ-** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
5. **ШУТИС-** Шинжлэх ухаан технологийн их сургууль
6. **ДХИС-** Дотоод хэргийн их сургууль
7. **ЦХИХХЯ-** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
8. **ААН-** Аж ахуйн нэгж
9. **МАБМТ-** Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо
10. **ЖҮТ-** Жижиг үл тохирол
11. **АХ-** Анхаарах хэсэг
12. **ТЦА-** Тээврийн цагдаагийн алба
13. **ИТХ-** Иргэдийн төлөөлөгчдийн хурал
14. **УЗ-** Удирдах зөвлөл
15. **БНСУ-** Бүгд Найрамдах Солонгос Улс
16. **БНХАУ-** Бүгд Найрамдах Хятад Ард Улс
17. **KIDI-** Korean Insurance Development Institute
18. **ЕБС-** Ерөнхий боловсролын сургууль
19. **ЖДС-** Жолоочийн даатгалын сан
20. **ГҮТББ-** Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага



## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Н.ХҮДЭРЧУЛУУН**  
Удирдах зөвлөлийн дарга

*Холбооны эрх барих дээд байгууллага нь  
Удирдах зөвлөл юм.*

*Удирдах зөвлөл нь холбооны дүрмийг  
батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,  
стратегийг төлөвлөгөө батлах, хяналт  
тавих, үйл ажиллагааг холбогдох  
байгууллагуудад тайлагнах зэрэг эрх,  
үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.*

”



**З.БАТБОЛД**  
Удирдах зөвлөлийн гишүүн



**Б.ЖАВХЛАН**  
Удирдах зөвлөлийн гишүүн




**Ж.БАТЖАРГАЛ**  
Удирдах зөвлөлийн гишүүн



**Б.РАГЧАА**  
Удирдах зөвлөлийн гишүүн



**Г.МӨНГӨНШАГАЙ**  
Удирдах зөвлөлийн гишүүн



**Б.АМАРБАЯСГАЛАН**  
Удирдах зөвлөлийн гишүүн



# 2025 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

## 01

Жолоочийн даатгалын гэрээг урьдчилж хийдэг боллоо.

## 02

Баталгаажсан гэрээнд нэр дурдсан жолоочийг нэмдэг болгов.

## 03

Жолоочийн даатгалын системд ДАН системийг нэвтрүүлэв.

## 04

Ипотекийн даатгалын мэдээллийн санг бүрдүүлж эхэллээ.

## 05

E-Mongolia системээс жолоочийн даатгалын лавлагаа мэдээлэл авах боломжтой болов.

## 06

Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001 стандартын гэрчилгээ авав.

## 07

Улсын хэмжээнд “Би хариуцлагатай жолооч” аяныг өрнүүллээ.

## 08


Говийн бүсийн ЕБС-ийн 1000 гаруй сурагчдад сургалт хийв.

## 09

БНСУ-ын Даатгалын хөгжлийн хүрээлэнтэй хамтын ажиллагаа эхлүүлээ.

## 10

Даатгалын мэдээлэл солилцох, зэрэглэл тогтоох Азийн форумд оролцлоо.



# НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

## 1.1 ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Албан журмын даатгагчдын холбоо нь Удирдах зөвлөлөөр батлуулсан дүрэм, Даатгалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулиар тусгайлан заасан эрх, үүргийн дагуу төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

2025 онд Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын төсвийг батлах, Холбооны гишүүнээр элсүүлэх, Холбооны гишүүний хураамж, татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн батлах тухай, Гадаадад албан томилолтоор ажиллуулах, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэн ажиллах тухай найман тогтоолыг хэрэгжүүлэн ажиллалаа.





## УДИРДАХ ЗӨВЛӨЛД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАВ



Удирдах зөвлөлийн 2025 оны гуравдугаар хуралдааныг 12 дугаар сард хуралдуулж холбооны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж амжилттай ажилласан гэж дүгнэв.

Мөн тус өдрийн хуралдаанаар АЖДХ-ны Ажлын албаны 2026 оны төлөвлөгөө, бүтэц, орон тоог шинэчлэн баталсны зэрэгцээ Жолоочийн даатгалын сангийн 2026 оны бүрдүүлэлт, зарцуулалт, холбооны төсвийг хэлэлцэн батлав.

### "ИНШҮРКО ДААТГАЛ" ХХК-ИЙГ ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭВ



"Иншүрко даатгал" ХХК нь СЗХ-ны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 46 дугаар тогтоолоор Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авав. Улмаар Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн 2025 оны нэгдүгээр хуралдаанаар холбооны гишүүнээр элсүүлж, гишүүний батламжийг тус компанийн Гүйцэтгэх захирал Б.Солонгод гардуулав.

### 20 ГАРУЙ УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ХИЙВ

Холбоо нь 2025 онд Сангийн яам, СЗХ, Нийслэлийн ИТХ, ЦЕГ, ТЦА, даатгалын компаниуд, зуучлагч, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зах зээлийн холбоо болон бусад төлөөлөл оролцсон 20 гаруй удаагийн ажлын хэсгийн хуралдаан, уулзалт, сургалт, хэлэлцүүлэгт оролцов. Энэ хүрээнд даатгалын мэдээллийн сангийн МИИС системийн шинэчлэлт өөрчлөлт, даатгалын салбарын холбогдох хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлт, хэрэгжилт, анхаарах асуудалтай холбоотой мэдээллийг танилцуулж, харилцан мэдээлэл солилцож ажиллалаа.





## 1.2 ХОЛБООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ

**АЖДХ нь 2025 онд Удирдах зөвлөлөөр батлагдсан дараах таван зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.**

**Үүнд:**

1. Даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
2. Жолоочийн даатгалын сан бүрдүүлэх, нөхөн төлбөр олгох, буцаан нэхэмжлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
3. Зам тээврийн осол буюу даатгалын тохиолдлыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа
4. Хамтын ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
5. Жолоочоос шалтгаалан гарсан зам, тээврийн ослын талаарх мэдээллийг хүлээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн, зөв тодорхойлох боломжийг бүрдүүлэх, дуудлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

# ЦАХИМААР ДААТГУУЛЖ ЦАГАА ХЭМНЭЭРЭЙ


*Жолооч та  
жолоочийн  
хариуцлагын албан  
журмын даатгалын  
гэрээгээ цахимаар  
байгуулснаар цаг  
хугацаа хэмнэж,  
цаасан зардлыг  
бууруулахад хувь  
нэмэр оруулах  
боломжтой*

Даатгалын гэрээ хүчинтэй эсэхийг  
шалгах бол:

- E-Mongolia
- E-Barimt
- Smartcar
- Autobox
- Даатгалын компанийн цахим системд хандана уу.

Гэрээний хугацаа дууссан, хүчингүй  
болсон бол:

- Smartcar
- Gerege
- Hiray
- Toki
- Даатгалын компанийн цахим системд тус тус хандаж төлбөрөө баталгаажуулж, гэрээгээ байгуулаарай.





# ХОЁР. ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1 ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА





## 2.1.1 МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ХАМРАХ ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ



### 37 УДААГИЙН НЭМЭЛТ МОДУЛЬ ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙЖ НЭВТРҮҮЛЛЭЭ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас баталсан журмын дагуу Даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн цахим өгөгдөл, МИИС системийг хадгалж буй серверийг “Үндэсний дата төв”-д төрийн үүлэн системийн тооцооллын серверт бүрэн шилжүүллээ. Даатгалын мэдээллийн нэгдсэн санд нийт 37 удаагийн нэмэлт модуль хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн байна.



### АВТОМАТЖУУЛАЛТ

Холбооны хэрэглэгч бүрийн хандалтын түүх, мэдээллийн урсгал зэргийг Жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллийн нэгдсэн санг 7 хоног бүр автоматаар сервер компьютерт бүрэн нөөцөлж хадгалдаг болов.



### ХУР СИСТЕМД ХОЛБОГДОВ

2025 онд ЦХИХХЯ-тай байгуулсан гэрээний хүрээнд Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээс хуулийн этгээдийн хураангуй мэдээлэл, Импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийн мэдээлэл зэргийг даатгалын мэдээллийн нэгдсэн санд татан авдаг боллоо.





## СИСТЕМИЙН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

Өгөгдлийн сангийн мэдээлэл дамжуулах хурд нэмэгдэж, сүлжээний нууцлал, аюулгүй байдал, өгөгдлийн сангийн нөөцлөх чадвар дээшилж, системийн тасралтгүй найдвартай байдал сайжирлаа. Үр дүнд гэрээ хийх хугацаа 3-5 минут байсан бол нэг минут болж богиносгов.




### ГЭРЭЭГ УРЬДЧИЛЖ ХИЙДЭГ БОЛЛОО

Даатгуулагч гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнөх 30 хоногийн дотор гэрээгээ сунгах боломжтой болов. 2025 оны 03 дугаар сараас хойш урьдчилж хийсэн нийт гэрээний тоо 62,210, хураамж 3.24 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс жолоочийн тоо хязгаарласан 40,770, жолоочийн тоо хязгаарлаагүй 21,440 гэрээ байна.


#### Урьдчилж хийсэн гэрээний тоо

Жолоочийн тоо хязгаарласан



**65.5%**  
40.770 гэрээ

Жолоочийн тоо хязгаарлаагүй



**34.5%**  
31.440 гэрээ

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт гэрээний тоо-62.770


## ДАН СИСТЕМД ХОЛБОГДОВ

### ДАН-ГААР БАТАЛГААЖСАН АЖИЛТНЫ ТОО

**ТӨЛӨӨЛӨГЧ-62**

**ЗУУЧЛАГЧ-649**

**ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЭРХ  
БҮХИЙ АЖИЛТАН-951**



ДАН-гаар баталгаажсан эрх бүхий  
ажилтны тоо-1662

Даатгуулагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2025 оны 10 дугаар сараас эхлэн МИИС системийг ДАН системтэй холболоо. Энэ дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан даатгалын ажилтан, төлөөлөгч, зуучлагч нарыг жолоочийн даатгалын мэдээллийн санд нэвтрүүлэхдээ танилт нэвтрэлтийн ДАН системээр баталгаажуулдаг болов.




### НЭР ДУРДСАН ЖОЛООЧ НЭМЭХЭД ХЯЛБАР БОЛОВ

Баталгаажсан гэрээнд нэр дурдсан жолоочийг сайн дураар нэмэх боломжтой болов. Өмнө нэр дурдсан жолоочийг баталгаажсан гэрээнд нэмэхдээ хүчинтэй гэрээг заавал цуцалдаг байсан юм. Уг шийдвэр хэрэгжиж эхэлсэнээс хойш буюу 2025 оны 10 дугаар сараас он дуусах хүртэлх хугацаанд энэ төрлийн гэрээний тоо 163-д хүрсэн байна. Үүнээс хуулийн этгээд 49, хувь хүн 114 байна. Хураамжийн орлого 7,6 сая төгрөг төвлөрсөн байна.


#### Баталгаажсан гэрээнд нэр дурдсан жолоочийг нэмсэн гэрээний тоо

Хувь хүн



**70%**  
114 гэрээ

Хуулийн этгээд



**30%**  
49 гэрээ

2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт гэрээний тоо-163



## И-МОНГОЛИА СИСТЕМЭЭС ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БҮХ ТӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ АВЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛДАГ БОЛОВ

И-Монголиа системд жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн лавлагаа мэдээлэл болон гэрээ дуусаж буй тухай анхааруулга илгээх боломжтой холболтыг хийлээ. Тус системээр бусад байгууллагуудад мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлж, хамтран ажиллах гэрээний хүрээнд И-Монголиа 5.0 платформд жолоочийн даатгалын гэрээ болон нөхөн төлбөрийн мэдээллийг харуулах системийг боловсруулан мэдээлэл нийлүүлж байна.

Мөн цахим даатгал хийх боломж бүхий MINI APP системийн холболтыг хийлээ. Ингэснээр даатгуулагч И-Монголиа төрийн үйлчилгээний системийг ашиглан жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийх, мэдээллийн нэгдсэн сангаас жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээлэл, лавлагааг авдаг болсон. Даатгуулагч, жолоочийн даатгалаар нөхөн төлбөр авсан эсэх, хэрэв авсан бол хэзээ, аль даатгалаас, ямар тээврийн хэрэгслээр осол гаргаж нөхөн төлбөр гаргасан талаар дэлгэрэнгүй мэдээллийг лавлагаа хэлбэрээр тус тус авч байна. Мөн гэрээний хугацаа дууссан бол цахимаар даатгалаа хийх боломжийг бүрдүүлж, жолоочийн даатгалын үйлчилгээг иргэдэд илүү ойр, хялбар хүртээмжтэй хүргэдэг болгов.

### И-Монголиа системээс жолоочийн даатгалын үйлчилгээ авсан иргэдийн тоо




2025 оны 12 дугаар сарын 31-ний  
байдлаар нийт иргэдийн тоо-972.697

#### Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ

2025 онд 889.746 иргэн  
Жолоочийн хариуцлагын албан  
журмын даатгалын гэрээ хийжээ.

2025 онд 889.746 иргэн  
Жолоочийн хариуцлагын албан  
журмын даатгалын гэрээ  
29 хувь буюу 258.017 гэрээг  
цахимаар байгуулав.



## СИСТЕМИЙН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

2025 онд Даатгалын зуучлагч компаниудын МИИС системтэй холбогдсон API холболтоор дамжуулан Toki, Ubcab, Smartcar, Hi pay зэрэг апплейкшнээр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 258,017 цахим гэрээг 39 ААН хийсэн нь нийт гэрээний 29 хувийг эзэлж байна.



## 2.1.2 ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ ШИНЭЭР БҮРДҮҮЛЭХ АСУУДЛЫГ СУДАЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ


Даатгалын хамгаалалтын хэмжээг 5-6 дахин нэмэгдүүлж, даатгуулагч болон түүний гэр бүл санхүүгийн хүндрэлд орох, орон байраа алдах зэрэг эрсдэлээс зээлийн хугацаанд даатгалаар бүрэн хамгаалах шаардлага үүссэн. Тиймээс зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийг урт хугацааны даатгалд хамруулан, гэнэтийн осол, өвчлөл зэрэг аливаа шалтгааны улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах тохиолдолд даатгагч зээлийн үлдэгдлийг төлж барагдуулах тухай СЗХ-ны 2025 оны 66 дугаар тогтоол батлагдсан байдаг.

Уг шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд даатгалын мэдээллийн нэгдсэн системд ипотекийн даатгалын мэдээллийг бүрдүүлж эхэллээ. Тайлант хугацаанд МИИС системд нийт 14,5 мянган ипотекийн даатгалын гэрээ бүртгэгдэж, 2,6 орчим тэрбум төгрөгийн хураамж төвлөрсөн байна.

**Даатгалын компани тус бүрээр ипотекийн мэдээллийн санг бүрдүүлсэн мэдээллийг харуулбал:**

№	Даатгалын компани	Гэнэтийн осол		Амь нас		Барьцаа хөрөнгийн		Нийт	
		Гэрээний тоо	Хураамжийн дүнГ	Гэрээний тоо	Хураамжийн дүнГ	Гэрээний тоо	Хураамжийн дүнГ	Гэрээний тоо	Хураамжийн дүнГ
1	АМАР ДААТГАЛ ХХК	-	-	-	-	1,922	366,051,488	1,922	366,051,488
2	Агис менежмент даатгал	-	-	5	1,042,601	14	2,754,478	19	3,797,079
3	Ард даатгал	-	-	-	-	7,206	1,115,631,350	7,206	1,115,631,350
4	Иншүрко даатгал ХХК	-	-	-	-	330	51,245,713	330	51,245,713
5	Мандал Лайф Даатгал ХХК	-	-	180	90,120,578	-	-	180	90,120,578
6	Монгол даатгал	-	-	1,367	182,546,083	3,025	619,751,098	4,392	802,297,181
7	Номин даатгал ХХК	-	-	-	-	6	1,404,945	6	1,404,945
8	Нэйшнл Лайф Даатгал ХХК	-	-	1	99,000	250	-	251	99,000
9	Тэнгэр даатгал	32	6,279,536	102	26,072,982	-	68,088,780	134	100,441,298
10	Хаан даатгал ХХК	-	-	-	-	104	23,366,163	104	23,366,163
Нийт		32	6,279,536	1,655	299,881,244	12,857	2,248,294,015	14,544	2,554,454,795

№	Даатгалын компани	Гэнэтийн осол		Амь нас		Барьцаа хөрөнгийн		Нийт	
		Т/тоо	НТ дүнГ	Т/тоо	НТ дүнГ	Т/тоо	НТ дүнГ	Т/тоо	НТ дүнГ
1	АМАР ДААТГАЛ ХХК	-	-	-	-	-	-	-	-
2	Агис менежмент даатгал	-	-	-	-	-	-	-	-
3	Ард даатгал	-	-	-	-	-	-	-	-
4	Иншүрко даатгал ХХК	-	-	-	-	-	-	-	-
5	Мандал Лайф Даатгал ХХК	-	-	-	-	-	-	-	-
6	Монгол даатгал	-	-	-	-	2	5,238,021	2	5,238,021
7	Номин даатгал ХХК	-	-	-	-	-	-	-	-
8	Нэйшнл Лайф Даатгал ХХК	-	-	-	-	-	-	-	-
9	Тэнгэр даатгал	-	-	-	-	-	-	-	-
10	Хаан даатгал ХХК	-	-	-	-	-	-	-	-
Нийт		-	-	-	-	2	5,238,021	2	5,238,021





## 2.1.3 ДААТГАЛЫН КОМПАНИ, ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ

Жолоочийн даатгалын нэгдсэн системд бүртгэлтэй ч үйл ажиллагаа явуулаагүй зуучлагч, төлөөлөгч нарын мэдээллийг СЗХ-оос авч, эрхийг холбогдох журмын дагуу хаах үйл ажиллагааг зохион байгуулав. Нийт 3065 төлөөлөгч байснаас 2626 төлөөлөгчийн эрхийг хааж, 439 төлөөлөгчийг системд идэвхтэй төлөвт үлдээсэн. Үүнээс 62 төлөөлөгч даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Мөн бүртгэлтэй байсан 9584 даатгалын зуучлагч байснаас 8683 зуучийн эрхийг хааж, 901 эрх бүхий зуучийг идэвхтэй төлөвт үлдээсэн. Үүнээс 649 зуучлагч даатгалын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасан жолоочийн хариуцлагын даатгалтай холбоотой

мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, хяналт тавих үндсэн үүрэгтэй. Даатгалын мэдээллийн нэгдсэн санд гишүүн 17 даатгалын компаниас нийлүүлсэн даатгалын хүчинтэй гэрээний тоо, хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийн тоо, дүн зэргийг нэгтгэж боловсруулахад мэдээллийн зөрүүнээс шалтгаалан тайлан мэдээ шаардлага хангахгүй байсан. Тиймээс мэдээллийн тулгалт хийж, даатгалын компаниудын гэрээ, нөхөн төлбөр хариуцсан ажилтнуудад мэдээллээ нягталж оруулах шаардлага тавьж, мэдээллийн сангийн журам, МИИС систем ашиглах гэрээний үүргээ биелүүлж, үнэн зөв тайлан гаргах, мэдээллийн санд нийлүүлэх талаар анхааруулж ажиллав.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн дата өгөгдлөөр нэгдсэн тайлан дүн, мэдээг улирал тутам өссөн дүнгээр гаргаж нэгтгэж байна. Үүнд:

- Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 17 даатгалын компаниуд 2025 оны жилийн эцсийн байдлаар 887,743 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 60,8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн. Нийт гэрээг ангилж харвал хувь хүний 621,830, хуулийн этгээдийн 239,314, мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн 18,420, дамжин өнгөрөхийн 8,179 гэрээ бүртгэгджээ.
- Холбооны даатгалын сан, гишүүн 17 даатгалын компаниас 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 24,393 жолоочийн даатгалын тохиолдол гарч, үүнд 29,9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Хохирлыг эрсдэлийн ангилал тус бүрээр авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан 24,211 даатгалын тохиолдолд 29,5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан 164 даатгалын тохиолдолд 326 сая төгрөгийн нөхөн төлбөр, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан 36 даатгалын тохиолдолд 67 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.
- Цуцлагдсан гэрээний тухайд хувь хүний жолоочийн даатгалын 21,423 гэрээ, хуулийн этгээдийн 11,718 гэрээ, мэргэшсэн C, D ангиллын 519 гэрээ, дамжин өнгөрөх 11 даатгалын гэрээ цуцлагдсан.
- Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 35 зуучийн компани 2025 оны жилийн эцсийн байдлаар 358,062 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 24,3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь нийт хураамжийн дүнгийн 39,9 хувийг эзэлж байна.



Жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллийн сан дахь мэдээллийг гишүүн байгууллагууд болон судлаач, оюутан, иргэдэд нээлттэй болгов. Мөн тайлан мэдээг бодит цагийн горимоор боловсруулан дашбоард хэлбэрээр [www.ami.mn](http://www.ami.mn) цахим хуудсаар олон нийтэд хүргэж байна.




Жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний тоо, хураамжийг харуулсан байдал



Жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн мэдээллийг харуулсан байдал



## 12202 ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЖ ШИЙДВЭРЛЭВ



Жолоочийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Цагдаагийн Ерөнхий газраас харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарт 2025.09.04-ний өдрийн 14/7872 дугаартай ажлын чиглэл хүргүүлсэн.

Энэ хүрээнд Тээврийн Цагдаагийн албатай хамтран, даатгалын компаниудын нөхөн төлбөр хариуцсан болон шуурхай албаны ажилтнуудад технологид суурилсан шийдлийг даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, даатгалын тохиолдлыг түргэн шуурхай шийдвэрлэх, зам тээврийн ослоос шалтгаалсан авто замын ачааллыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангаж


ажиллах талаар мэдээлэл өгч ажиллав. Нийт 12202 зөрчил илрүүлснээс нийслэлд 9093, орон нутагт 3109 нь бүртгэгдсэн байна.

Нийслэлийн Засаг даргын Захирамжийн дагуу даатгалгүй этгээд замын хөдөлгөөнд оролцохгүй байх хуулийн заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнд 2025 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар импортоор орж ирсэн 63305, шилжилт хөдөлгөөн хийгдсэн 240312, нийт 303617 тээврийн хэрэгсэлд Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.1-д заасны дагуу жолоочийн даатгалыг хийлгэж ажилласан байна.

*Эх сурвалж: Нийслэлийн Авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв*

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ИТХ болон тус сумын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл”-тэй хамтран “Би хариуцлагатай жолооч” сарын аяныг 2025 оны 10 дугаар сараас 11 сар хүртэл хугацаанд өрнүүлсэн аяны хүрээнд хяналт шалгалтаар 125 даатгалгүй жолоочийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн дагуу 12,5 сая төгрөгөөр торгож, жолоочийн хариуцлагын даатгалд бүрэн хамруулж, зөрчлийг арилгаж ажиллав.





## 2.1.4 ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ДАХИН СУДАЛЖ, ШИНЭЧЛЭН ТООЦОЖ, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАД ХҮРГҮҮЛЖ БАТЛУУЛАН, ПРАКТИКТ НЭВТРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг шинэчлэх тооцоо судалгаа хийж, бодлогын даалгавар боловсруулан өгөгдлийн сангийн дэд бүтцийг бий болгож, МИИС системд хөгжүүлэлт хийлээ. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох системүүдийг холбож, 2025 оны 7, 8, 10, 12 дугаар сард холбогдох байгууллагуудад цахим сургалт хийж, уулзалт зохион байгуулав. Мөн даатгалын компаниуд болон зуучлагч байгууллагуудын санал

хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. 2025 оны нэгдүгээр сарын 6-ны өдөр Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг хэрэгжүүлэн ажилласан боловч 2025 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар хүчингүй болсон тул 2018 онд батлагдсан журмыг буцаан хэрэглэж байна.

## 2.1.5 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ХАР ЦЭГИЙН СУДАЛГААГ ШИНЭЧЛЭН ХИЙХ, ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын хэмжээнд осол ихээр бүртгэгдэх болсон "Хар цэг"-ийн судалгааг 2023-2024 оны байдлаар шинэчлэн гаргах ДХИС-ийн судалгааны багийн ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа.

Улмаар 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр "Хар цэг"-ийн судалгааны үр дүнг холбооны Удирдах зөвлөлд танилцуулж, тодорхой цэгийг сонгон зам тээврийн ослыг бууруулах, даатгалын тохиолдоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар тогтлоо.



## 2.1.6 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ISO/IEC27001:2022 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ, ХӨНДЛӨНГИЙН АУДИТААС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ



Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлэх Ажлын хэсэг байгуулж, Зөвлөх үйлчилгээ үзүүлэх “Инфосерт” ХХК болон зөвлөх аудитортай хамтран ажиллах гэрээ байгуулж, холбооны хэмжээнд дөрөв, хамтарсан хурлыг гурван удаа зохион байгуулж, ажилтнуудад гурван удаа Мэдээллийн аюулгүй байдлын сургалт хийв.

утсыг далдлах ажлыг стандартын шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн. МИИС системийн эх код, өгөгдлийн сан, сервер систем болон сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын дотоод аудит хийлгэсэн бөгөөд тухайн шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн системийн шинэчлэлийг хийж дуусгасан.

### ISO/IEC27001:2022

Тус стандартын 86 хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд 12 ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж, 17 журмыг байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулж, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулав.

“ABS Certification” 2025.10.15-20-ны өдрүүдэд хөндлөнгийн аудитаар шалгагдаж, 3 ЖҮТ, 15 АХ-тэйгээр стандартын шаардлага хангаж, ISO/IEC 27001:2022 олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Баталгаажуулалтын гэрчилгээг албан ёсоор хүлээн авлаа.

Удирдах зөвлөлийн хурлаар МАБМТ-ын стандартын шаардлагыг бүрэн хангаж ажиллах, 3 ЖҮТ, 15 АХ-тэй зөрчлийг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны нэгдүгээр улиралд багтаан тайлагнахаар тогтов.

Мөн Хөдөлмөрийн дотоод журамд МАБ-ын зохицуулалтыг шинээр тусгаж оруулсан. Ажлын байрны нууцлалтай бүсийг тодорхойлж, камержуулалт хийж, цахилгаан болон сүлжээний

Мөн харьяа дүүргийн Онцгой байдлын хэлтсээр ажлын байрны орчин нөхцөлд галын эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж, илэрсэн зөрчлийг арилгаж мэргэжлийн байгууллагын “Галын дүгнэлт” авсан нь аудитаар онцлох давуу тал болов.




## 2.2.1 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 22.1.3, 22.1.5-Д ЗААСНЫ ДАГУУ ЭХ ҮҮСВЭРИЙГ ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ

### Удирдах зөвлөлийн 03 дугаар тогтоолын хэрэгжилт

*“Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйл, Холбооны удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолын дагуу 2025 онд Жолоочийн даатгалын санд 2,8 орчим сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан. Тайлант хугацаанд нийт 3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлт 108.9 хувь байна”*

### Жолоочийн даатгалын санд орлого төвлөрүүлсэн байдал



АЖДХ-ны Удирдах зөвлөлийн хурал-2025.12 дугаар сар



**Жолоочийн даатгалын сангийн орлогын бүтэц**




Орлогын гүйцэтгэлийн 59 хувийг сангийн хөрөнгийг байршуулсан банкнуудаас орж ирж байгаа хүүний орлого эзэлж байна. Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасан эх үүсвэр 41 хувийг эзэлж байна.

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг холбогдох журамд заасны дагуу Төрийн банк, Голомт банк болон Голомт капитал ҮЦК, "Монимаркет фонд"-д харилцах, хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалтын хэлбэрээр байршуулж байна.

Тайлант хугацаанд жолоочийн даатгалын сангаас 23 иргэн нөхөн төлбөр хүссэн өргөдөл ирүүлснийг холбогдох эрх зүйн актуудын дагуу хянан 110,6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын тохиолдлын хохирогчдод олгож, буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх ажиллагаа хийгдэж байна. Нөхөн төлбөрийн өргөдөл шийдвэрлэлт 100 хувь байна.

Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр аваад хугацаа хэтэрсэн 43 иргэн, хугацаандаа төлж байгаа 20 иргэн байна.





**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН  
ДААТГАЛДАА ХАМРАГДАЖ  
ХАЙРТАЙ БҮХНЭЭ ЭРСДЭЛЭЭС  
ХАМГААЛААРАЙ**

**Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.2**

**Тээврийн хэрэгслийн өмчлөгч  
жолоочийн хариуцлагын  
даатгалд даатгуулаагүй бол:**



**Замын хөдөлгөөнд  
оролцох;**



**Техникийн хяналтын  
үзлэгт оруулах;**



**Улсын бүртгэлд  
бүртгүүлэхийг хориглоно**



**1800-1177**



**www.ami.mn**



**info@ami.mn**



## 2.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ БУЮУ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ БУУРУУЛАХАД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



### 2.3.1 Зорилтот бүлэгт чиглэсэн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ

Сургалт, судалгаа, сурталчилгаа гэсэн чиглэлээр нийт 29 арга хэмжээ бүхий ажлын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлуулж, хэрэгжүүлэн ажиллалаа.

### “Сурагчийн аюулгүй байдал” сургалтыг зохион байгууллаа

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах нийгэмлэгтэй хамтран 2025 оны 10 дугаар сард Говьсүмбэр, Дорноговь аймгийн ЕБС-ийн 1000 гаруй сурагчид “Сурагчийн аюулгүй байдал” сургалтыг зохион байгууллаа.



### Замын-Үүд суманд ажиллав

Улсын босоо тэнхлэгийн А0103 зам дагуу буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 100 гаруй төрийн албан хаагч, даатгалын компанийн ажилтан, тээврийн жолооч нарт 2025 оны 10 дугаар сард зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, Жолоочийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт мэдээлэл өгөв.





# СУРГАЛТ



- Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан санамж бичгийн хүрээнд Тээврийн цагдаагийн алба болон “Бодь даатгал” ХК-тай хамтран, “Премиум Нэксус Ложистик” ХХК-ийн хүргэлтийн үйлчилгээний 70 жолоочийг сургалтад хамруулав.



- “Смарткар”-тай хамтарч автобус, нийтийн тээврийн хэрэгсэл дээр “Жолоочийн хариуцлагын даатгалаа цахимаар” сурталчилгааг 2025 оны 8 дугаар сард байршууллаа.



- “Бодь даатгал” ХК, ТЦА-тай хамтран “Ханбогд” ХХК-ийн Оюу Толгойн ажилчдад үйлчилдэг тээврийн жолооч нар т зориулсан сургалтыг зохион байгуулав.



- Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан “Санхүүгийн зах зээл” өдөрлөгт хамтран оролцож “Сити” их сургууль болон Монгол Улсын Их Сургуулийн оюутан залууст сургалт хийв.



- Говьсүмбэр, Дорноговь аймгийн нутаг дэвсгэр, улсын босоо тэнхлэгийн А0103 зам дагуу зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх 11 ширхэг сурталчилгааны самбар байршуулав.



- Монголын даатгалын зах зээлийн холбоотой хамтран даатгалын салбарын “Шинэ ажилтны сургалт”-д Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, анхаарах зүйл сэдэвт сургалт хийв.



**“2025 онд нийт зорилтот бүлгийн 39 хуулийн этгээдэд чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг 1583 иргэнд хүргэн ажиллав”**

- Ипотекийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх сургалтыг 2025 оны наймдугаар сард 14 даатгалын компанийн ажилтан, 2025 оны есдүгээр сард Төрийн банк, Хаан банк, Ариг банк, Тээвэр хөгжлийн банк, Голомт банк, Богд банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг найман арилжааны банкны ажилтнуудад тус тус зохион байгууллаа. Сургалтаар холбооны Системийн ахлах администратор О.Мөнхбат ипотекийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн системийн бүтэц, зохион байгуулалт, тайлагнал зэрэг асуудлаар зааварчилгаа, арга зүйн зөвлөмж, мэдээллийг өгөв.
- Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран “Өнөр бүл” хүүхдийн төвийн зорилтот бүлгийн суралцагчдад сургалт хийв.
- Тээврийн хэрэгслийн өмчлөгч, жолооч нарт зориулан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”-ын гарын авлагыг шинэчлэв. Гарын авлагад жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдол, онцлог, даатгалд хамрагдах, гэрээ байгуулах, даатгалын хураамжийг хэрхэн тооцох, даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, жолоочийн даатгалын нөхөн төлбөрийн тухай, Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм, зам тээврийн ослын үед авах арга хэмжээ зэрэг мэдээллийг багтаасан.







**“Би хариуцлагатай жолооч” контент бүтээх уралдааны шилдгүүд**

## СУРТАЛЧИЛГАА

- 2025.06.15-нд “Би хариуцлагатай жолооч” контентын уралдааныг дүгнэж, эхний 3 байрыг шалгаруулж, бүтээлийг АЖДХ-ны цахим хуудсаар олон нийтэд түгээлээ.
- ЗХАБХН, “Авто радио 96,3”-тай хамтран 2025 оны 6-9 сарын хооронд **“Жолоочийг хариуцлагажуулъя”** цуврал 18 видео, 5 рийл, 10 постер, “Даатгал таныг эрсдэлээс хамгаална” сэдэвт ярилцлага 2, нэвтрүүлэг 5, постер 4-ийг бэлтгэж, олон нийтэд түгээв.
- Жолоочийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг иргэд, олон нийтэд таниулах чиглэлээр постер, контент бэлтгэж, холбооны цахим хуудсаар түгээлээ.
- Жолоочийн даатгалын системд ДАН-г нэвтрүүлсэн, даатгалын гэрээг цуцлахгүйгээр жолооч нэмдэг болсон тухай, E-Mongolia системээс жолоочийн даатгалын гэрээний мэдээлэл, нөхөн төлбөрийн лавлагааг авдаг болсон тухай, цахимаар даатгуулах тухай, Жолоочийн хариуцлагын даатгалын мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэн мэдээллийн тоймыг улирал бүрээр бэлтгэсэн видео, постер зэрэг контентыг бэлтгэж холбооны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллав.
- Замын-Үүд сумын “Талант студи” “Хамтдаа хамгаалъя” подкастыг 2025 оны аравдугаар сард Замын-Үүд сумын ИТХ-ын ажлын албаны цахим хуудсаар олон нийтэд хүргэв.





## ХАМТАРСАН СУРТАЛЧИЛГАА




Тээврийн цагдаагийн алба, даатгалын холбоод, даатгалын компанийн төлөөллийг оролцуулан хууль сурталчлах хүрээнд телевизийн болон сайтын мэдээ, постер тус тус хийж, сурталчлан ажиллав.

## ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ СУРТАЛЧЛАВ

Ослын тодорхой тохиолдолд цагдаагийн оролцоогүйгээр даатгалын компанидаа хандаж цахимаар шийддэг болсон тухай рийлс, телевиз, сайтын мэдээ тус тус бэлтгэж, мэдээлэл тус бүрийг АЖДХ-ны сошиал хуудсаар түгээж ажилласан.



## ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ НЭМЭГДЭВ



2025 онд Холбооны [www.ami.mn](http://www.ami.mn) цахим хуудсаар давхардсан тоогоор 27.297, Албан журмын даатгагчдын холбоо сошиал хуудсаар 431.5 мянган иргэн зочилж, холбооны мэдээллүүдтэй танилцжээ. 2025 оны эцсээр Албан журмын даатгагчдын холбооны пэйжийн дагагчдын тоо 33 мянгад хүрсэн байна.






## 2.3.2 ДААТГАЛЫН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ СУДАЛЖ НЭВТРҮҮЛЭХ (ТРА-THIRD PARTY AGENCY)



Албан журмын даатгагчдын холбоо нь даатгалын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Конкорал” ХХК-тай хамтран БНХАУ-ын даатгалын салбараас туршлага судалж, “Жолоочийн даатгалын нөхөн төлбөрийн үйлчилгээний өнөөгийн байдал, чанар, хүртээмжийг сайжруулах шийдэл, санал” сэдвээр судалгаа хийж, судалгааны үр дүнг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Холбооны гишүүн даатгалын компанийн удирдлагуудад танилцуулсан. Уг уулзалтаар Монгол улсын

даатгалын салбарт ТРА нэвтрүүлэх боломж, даатгалын салбарт тулгамдаж буй жолоочийн даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтэд даатгуулагчийн сэтгэл ханамж болоод хүлээлт ямар байгааг тодруулж, даатгалын компаниуд цаашид юунд анхаарч ажиллах, үйлчилгээндээ технологийн дэвшлийг нэвтрүүлж, иргэдэд хүртээмжтэй үйлчлэх, даатгагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, ил тод, хурдан шуурхай нөхөн төлбөр олгох арга замуудын талаар хэлэлцлээ.

## 2.4 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2.4.1 ЖОЛООЧИЙН  
ДААТГАЛЫН ОЛОН  
ТАЛТ ХАМТЫН  
АЖИЛЛАГАА БИЙ  
БОЛГОХ АСУУДЛЫГ  
СУДАЛЖ,  
ХЭРЭГЖҮҮЛЖ  
ЭХЛЭХ



## БНСУ-ын Даатгалын хөгжлийн хүрээлэнтэй хамтын ажиллагааг эхлүүлэв

БНСУ-ын Даатгалын хөгжлийн хүрээлэн (KIDI)-ийн Гүйцэтгэх захирал ноён Чанг Еон Хё тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол улсад урьж, 2025 оны 8 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд албан ёсны уулзалт хийлээ. Уг уулзалтын хүрээнд хоёр байгууллага хамтран ажиллах Санамж бичиг байгуулав. Талууд даатгалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хамтарсан сургалт семинар зохион байгуулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, харилцан туршлага, мэдээлэл солилцох зэрэгт хамтран ажиллахаар тохиролцлоо.



## БНСУ-ын Бусан хотын туршлагыг судлав

Нийслэлийн ИТХ, ТЦА, АЖДХ зэрэг байгууллагын төлөөлөл БНСУ-ын Бусан хотын цагдаагийн газрын замын хөдөлгөөний мэдээллийн төвийн камерын хяналтын үйл ажиллагаа, зам тээврийн ослын дуудлага, мэдээллийг хүлээн авах, цагдаагийн байгууллагад ирж буй дуудлага, мэдээллийн нөхцөл байдал, Дижитал криминалистикийн хэсэг, программ хангамж, даатгалын систем зэрэгтэй танилцаж, салбарын төлөөлөлтэй уулзлаа. Тус хотын "Samsung" даатгалын байгууллагын алба хаагчидтай уулзаж, зам тээврийн ослын даатгалын тохиолдлыг цахим болон автоматжуулсан системээр хэрхэн хүлээн авч шийдвэрлэж байгаатай танилцаж туршлага судлав.



## Судалгааны үр дүнг танилцуулав

"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад даатгалын нөлөөлөл" сэдвийн хүрээнд судалгаа хийв. ДХИС-ийн зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд оролцож, тус сургуулиас гаргасан эмхэтгэлд уг судалгааг орууллаа. Судалгаагаар даатгалын салбарын үйлчилгээний чанар, хүртээмжид тандалт хийсэн бөгөөд 21 аймаг, нийслэлээс 502 жолооч, даатгуулагч иргэнээс 19 төрлийн асуулга авсан байна. Судалгааны үр дүнг 2025 оны 3 дугаар сард Санхүүгийн зохицуулах хороонд, 11 дүгээр сард Бодлогын зөвлөлд танилцуулж, Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал орууллаа.





**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХУРАЛ-2025.04.11**



Замын хөдөлгөөний дүрэм үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ЗТЯ-тай хамтран эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах нийгэмлэгтэй хамтран “Би хариуцлагатай жолооч” уриалгыг дэвшүүлэн ажиллав.

**ХАМТАРСАН АЖЛЫН  
ХЭСЭГ-2025.8.29**



Нийслэлийн ИТХ-аас мэргэжлийн байгууллагуудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулав. Уг ажлын хэсэгт АЖДХ орж нийслэлийн замын ачааллыг бууруулах чиглэлээр хамтарч ажиллах талаарх хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулж, тодорхой асуудалд холбогдох шийдвэрийг гаргууллаа.

**МАСТЕР ГЭРЭЭ-2025.03.18**



- “Албан Журмын Даатгагчдын Холбоо” ГҮТББ мөнгөний захад нэгдэж, Итгэл хүлээлгэгчийн Мастер гэрээ байгууллаа.
- Санхүү эдийн засгийн их сургуулийн “Даатгалын салбарын судалгаа”-ны ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллав.

**“DASHCAM” АЯН-2025.05.19**



Монголын Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандартад заасны дагуу “Албан журмын даатгагчдын холбоо” нь “Юбикаб” ХХК-тай хамтарч, “DASHCAM” аяныг эхлүүлээд байна. Тус аяны хүрээнд стандарт такси үйлчилгээнд бүртгэлтэй автомашинд “Dashcam” буюу автомашины хяналтын төхөөрөмж, бидний хэлж хэвшсэнээр хар хайрцгийг суулгаж, жолоодлогын үеийн мэдээлэл, бичлэгийг хадгалах боломжтой болох юм.

**САНАМЖ БИЧИГ-2025.06.12**



Холбоо нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хамгаалах нийгэмлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, Авторадио 96.3 долгионоор зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр цуврал подкаст хийлээ.

**МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХЭЭР  
ТОХИРОЛЦОВ**



Монгол Улсын автотээврийн хяналтын үзлэгийн чадавхыг бэхжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төслийн багийн удирдагч ноён Сангвүүнг Пак-тэй уулзаж, Койкагаас хэрэгжүүлж буй төсөлд Холбооны зүгээс автотээврийн бүртгэл, үзлэгт даатгалын гүйцэтгэх үүрэг, төслөөс хэрэгжүүлэх автотээврийн нэгдсэн системд даатгалын мэдээллийг нийлүүлж хамтран ажиллахаар тохиролцов.



## 2.5 ЖОЛООЧООС ШАЛТГААЛАН ГАРСАН ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН, ЗӨВ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ

### 2.5.1 ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ГАЗАР ДЭЭРХ ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ БОЛОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУС БҮРИЙГ ЦАХИМЖУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ

#### ОСЛЫН ШАЛТГААНЫГ ДАТА-Д СУУРИЛАН ТОГТООНО



#### САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАВ



Зам тээврийн ослын мэдээллийг үнэн зөв, бодит цагийн горимоор бүртгэх боломжтой цахим платформ хөгжүүлэх төслийн хүрээнд АЖДХ, Дэлхийн банкны төслийн багийн төлөөлөлтэй уулзаж, төслийн зорилго, техник шийдэл, хамтын ажиллагааны боломжуудын талаар санал солилцов. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд зам, тээврийн ослын бүртгэлийг илүү нарийвчлалтай, газар зүйн байршил, цаг хугацааны дагуу тэмдэглэж, ослын нөхцөл, шалтгаан, давтамж зэрэгт дүн шинжилгээ хийх боломжтой системийг хөгжүүлж байна. Энэ платформ нь цаашид осол их гардаг "Хар цэг"-үүдийг илрүүлэх, ослын шалтгааныг дата-д суурилан тодорхойлох, түүнчлэн холбогдох байгууллагуудын оновчтой шийдвэр гаргахад бодит дэмжлэг үзүүлэх чухал хэрэглүүр болох юм.

Зам тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албатай хамтран даатгалын компанийн нөхөн төлбөр хариуцсан ажилтнуудад "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зөрчлийн онцлог" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтаар замын хөдөлгөөнийг зохицуулж ирсэн түүх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын систем, зам, тээврийн ослын шалтгаан нөхцөл, орчны нөлөө, техникийн шинжилгээ, хэргийн газрын үзлэг, ул мөр, зам, тээврийн ослын дүгнэлт гаргахад Замын хөдөлгөөний дүрмийн хэрэглээ зэрэг сэдвээр мэдээлэл өгөв. Мөн даатгалын компанийн нөхөн төлбөр хариуцсан мэргэжилтнүүдийг Жолоочийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй зам тээврийн ослын нөхцөлд хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч чадавхжууллаа.



## 2.5.2 ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУГААРЫГ БИЙ БОЛГОХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ



### ХОЛБООНЫ ТУСГАЙ ДУГААРТ ХАНДСАН 4694 ДУУДЛАГЫГ ХҮЛЭЭН АВЛАА

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компанийн оператор, менежерүүдтэй холбогдож дуудлага хэрхэн авдаг, нөхөн төлбөрийн бүрдүүлбэр яаж явагддаг талаар мэдээлэл цуглуулж судалгаа хийлээ.

**70101177, 18001177** тусгай дугаарт нийт 4694 дуудлага хүлээн авч МИИС системд бүртгэж ажиллав.

"Телко коммуникэшнс" ХХК компанитай хамтран ажиллах гэрээгээр **1800-1177** тусгай дугаарыг ашиглаж байна. "Жолоочийн хариуцлагын даатгал" -ын гэрээний хугацаа нь дууссан 470,329 иргэнд даатгалын гэрээгээ сунгах сануулга мессеж илгээсэн байна.

2025 оны дуудлагын мэдээ	
Дуудлагын төрөл	Дуудлагын тоо
Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдол	125
Нөхөн төлбөрийн лавлагаа	357
Санал, гомдол	74
Даатгалын компанийн утасны дугаар, хаяг байршил	145
Хууль тогтоомжийн лавлагаа	96
Мэдээллийн сангийн лавлагаа	1,885
Даатгалын компани болон хугацааны лавлагаа	908
Бусад лавлагаа	870
Эргэн холбогдож хариу өгсөн дуудлагууд	234
<b>Нийт дуудлага</b>	<b>4,694</b>



# 1800-1177



# ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА



*АЖДХ-ны ажилчдын тайлангийн хурал-2025.12 дугаар сар*

## Санхүүгийн үйл ажиллагааг зөрчилгүй гэж дүгнэлээ

“Дум аудит” ХХК Албан журмын даатгагчдын холбооны 2025 оны санхүүгийн тайлан, санхүүгийн жилийн ашиг алдагдал, бусад орлого, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж, гүйцэтгэв.

Аудитаар Албан журмын даатгагчдын холбоо нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал, санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Жижиг, дунд аж ахуйн нэгжийн Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартын дүрэм, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж дүгнэгдлээ.

## Цаасгүй соёлыг нэвтрүүлж, бүрэн цахимжуулав

Ажлын алба нь цаасгүй соёлыг эрхэмлэн өдөр тутмын дотоод үйл ажиллагаандаа оффис 365 программ болон Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-Mongolia, Outlook, Teams E-Chat-апп ашиглан, ажилтнуудын цагийн бүртгэл, албан бичиг хуваарилалт, үүрэг даалгавар өгөх зэрэг үйл явцыг бүрэн цахимжуулсан.





АЛБАН ЖУРМЫН  
ДААТГАГЧДЫН ХОЛБОО  
Association of Mandatory Insurers



# nsur TALK

podcast



Даатгалын салбарын мэдлэг,  
мэдээллийг түгээнэ



Association of Mandatory Insurers  
**АЛБАН ЖУРМЫН  
ДААТГАГЧДЫН ХОЛБОО**

# “ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ ТАНЫГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛНА”

**ХАЯГ:**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Чингисийн өргөн чөлөө – 17,  
Гэрэгэ тауэр 12 давхар

---

**УТАС:**

1800-1177, 70101177, 70001277

---

**ЦАХИМ ХУУДАС:**

[www.ami.mn](http://www.ami.mn)

---

**ФЭЙСБҮҮК :**

Албан Журмын Даатгагчдын Холбоо

---